| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | 3.1.2.4. | Орон нутгийн жилийн төсвийн төсөлд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны урсгал зардал, хамтарсан багийн үйл ажиллагааны зардал, хохирогчид үйлчилгээнд шаардагдах зардлыг төсөвт тусгаж, батлуулах; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | 1.Батлагдсан төсөв 100%<br>2.Зардлын хуваарилалт, үйл ажиллагааны хэрэгжилт 95%-иас дээш түвшинд биелэх | 2024 онд баталсан төсөв | Орон нутгийн төсөвт урсгал зардал, үйл ажиллагааны зардал, үйлчилгээний зардлыг 100 хувь тусгаж, аймгийн ИТХ-аар батлуулсан байна. Хохирогчдод үзүүлэх үйлчилгээний хүртээмж, чанар нэмэгдсэн байна. | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар ТХБ-нд байраар үйлчилгээ авах хүсэлтэй насанд хүрэгчдийн хариу үйлчилгээний зардал болох 40,0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусгуулсан. | 124.5 сая | ОНТ | Засаг дарга данснаас Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын дэргэдэх түр хамгаалах байрны насанд хүрэгчдийн зардалд 2,9 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн. Тайлант онд түр хамгаалах байраар 10 насанд хүрэгч, 57 хүүхэд 487 хоног байрлаж аюулгүй байдлыг хамгаалан нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэн ажиллаа. Хүүхдийн хөгжил, оролцоо, хамгааллыг сайжруулах чиглэлээр нийгмийн ажилтнуудыг чадавхжуулах сургалт, Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ, Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн арга хэмжээ, Хамтарсан багийн гишүүдийг чадавхижуулах сургалт арга хэмжээ, хүүхэд, гэр бүлийн суурь судалгаа хийх, түр хамгааллах байрны үйл ажиллагааны зардалд нийт 124.5 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. 2025 оны төсөвт түр хамгаалах байрны урсгал зардал, цалин хөлс, урамшууллалд 100.0 сая төгрөгийг ИТХ-аар батлуулсан. | | 100 | Хэрэгжсэн |
| | НИЙТ | | | | | | | | | | | 94 | |
| | | | | | | 3.1.3. Хүүхдийн эрхийн талаар: | | | | | | | |
| 6 | 3.1.3.1. | Хүүхдийн эрх, хамгааллын салбар дундын төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх; | | 1.Төлөвлөгөө баталсан эсэх<br>2.Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | Хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хангахад салбар бүрийн оролцоо сайжирсан байна. | Хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 17 ажил,арга хэмжээ тусгагдсанаас хэрэгжилт 91 хувьтай байна. | - | - | Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийг 1 удаа хуралдуулж, 2024 онд хүүхдийн хөгжил оролцоо хамгааллын чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан, төлөвлөгөөний биелэлтийг хэлэлцэж, 2025 оны ажлын төлөвлөгөө баталсан. Сумдын Хүүхдийн төлөө зөвлөлийн ажил, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах, орон нутгийн төсвөөс хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр зардал тусгуулах, сумдын хүүхдийн төлөө зөвлөлийн ажлыг эрчимжүүлэх 2 чиглэл хүргүүлэх тухай албан бичиг хүргүүлж, 1 удирдамж гаргаж ажилласан. Тайлант онд 14 сумын Хүүхдийн төлөө зөвлөлийг хуралдуулж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ. Төлөвлөгөөний хэрэгжилт 91 хувьтай байна. | | 91 | Хэрэгжсэн |
| 7 | 3.1.3.2. | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлэх; | | Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн орон нутгийн нийт хүүхдэд эзлэх хувь | 2024 онд хамрагдсан хүүхдийн тоо | Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо 25 хувиар өссөн байна. | Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын дэргэдэх хүүхэд хөгжүүлэх 12 төрлийн дугуйланд 912 хүүхэд хамрагдаж өмнөх оны мөн үеэс 10 хувиар өссөн байна. | - | - | Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын дэргэдэх хүүхэд хөгжүүлэх 12 төрлийн дугуйланд 912 хүүхэд хамрагдлаа. Аймгийн хэмжээнд хүүхэд хөгжүүлэх 256 дугуйлан, секц, клуб үйл ажиллагаа явуулж 6000 гаруй хүүхэд сонирхсон чиглэлээрээ суралцаж хөгжиж, олон улс, улс, бүсийн чанартай 4 төрлийн 10 гаруй уралдаан, тэмцээнд 232 хүүхэд хамрагдаж аймаг, орон нутгийнхаа нэрийг гаргаж, амжилттай оролцлоо. | | 40 | Хэрэгжсэн |
| 8 | 3.1.3.3. | Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих салбар зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах төсвийг тухайн шатны ИТХ-аар батлуулах; | ######## | Баталсан төсвийн хэмжээ | 2024 онд баталсан төсөв | "Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих салбар зөвлөл"-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжсэн байна. | Бага насны хүүхдийн цогц бодлогыг хэрэгжүүлэх, салбар дундын 3 бүлэг 15 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг хангах хүрээнд 7 төрлийн урьдчилан сэргийлэх нөлөөллийн үйл ажиллагаанд 1300 гаруй бага насны хүүхдийг хамруулсан ба төлөвлөгөө"-ний хэрэгжилт 70 хувьтай хэрэгжсэн. | 4.1 сая | ОНТ | Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих орон тооны бус зөвлөлийг 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр Аймгийн Засаг даргын А/27 дугаартай захирамжаар байгуулсан "Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих салбар зөвлөл" хуралдаж 3 бүлэг 15 арга хэмжээг төлөвлөн Зуны сувилал, дархлаажуулалтын аян, шим тэжээлийн дэмжлэг, номтой нөхөрлөе дархлаажуулалтын аян, хөхөөр хооллолтын ач тус зэрэг 7 удаагийн арга хэмжээнд 1300 гаруй хүүхдийг хамруулан, төлөвлөгөөний хэрэгжилт 70 хувьтай байна. Мөн цэцэрлэгүүдтэй хамтран бага насны хүүхдийн амны хөндийн өвчлөл их байгаатай холбоотойгоор "Эрүүл шүд " арга хэмжээг 3 удаа зохион байгуулж 60 хүүхэд хамруулж цаашид сум бүрт Шүдний кабинетыг байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн ИТХ-д "Хүүхдийн хоол тэжээлийн шимт дэмжлэг" хөтөлбөрийг батлуулан 1-5 дугаар ангийн 10412, цэцэрлэгийн 6348 хүүхдэд 7 хоногийн 2 өдөрт 200гр сүү олгож байна. Мөн Шүдний урьдчилсан сэргийлэх, эрт илрүүлэх оношилгоонд 4217 хүүхэд хамрагдаж 1060 хүүхдэд эрдэсжүүлэх эмчилгээ хийгдсэн. Цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургуульд өдрийн цайны дараа "Шүд угаах" цагийг 10 цэцэрлэг, хэрэгжүүлдэг болсон. Мөн Ерөнхий боловсролын 17 сургуулийн шинээр шүд угаах цэгийг нэмэгдүүлж, цэцэрлэг болон сургуулийн багш нар амны хөндийн эрүүл мэндийн сургалтад хамрагдлаа. Амны хөндийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор "24/3 шүдээ зөв угаа" аян, "Шүд угаалтын аварга" шалгаруулах тэмцээнүүдийг зохион байгуулж, шүд угаах зөв дадал хэвшлийг төлөвшүүллээ. | | 70 | Хэрэгжсэн |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | 3.1.3.4. | Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9 дугаар заалтыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах; | 1.Тухайн жилийн татвар ногдох орлогоос 1 хүртэлх хувийг нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан байгууллагын тоо 2.Зарцуулсан хөрөнгийн хэмжээ /сая. төг/ | - | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг 100 хувь хангасан байна. | Жилийн эцсийн байдлаар татвар ногдох орлогоос 1 хүртэлх хувийг нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан байгууллага байхгүй. | - | - | Жилийн эцсийн байдлаар татвар ногдох орлогоос 1 хүртэлх хувийг нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан байгууллага байхгүй. | | 100 | Хэрэгжсэн |
| 10 | 3.1.3.5. | Аймгийн Хүүхдийн зөвлөл, хүүхдийн оролцооны байгууллагуудыг байр танхимаар хангах, шийдвэр гаргах түвшинд хүүхдийн оролцоог хангах ажиллах; | Байр танхимаар хангасан оролцооны байгууллагын тоо | - | Хүүхдийн оролцооны байгууллагуудын үйл ажиллагаа сайжирсан байна. | Байр танхимаар хангасан оролцооны 17 байгууллага байна. | - | - | Аймгийн хэмжээнд 17 хүүхдийн зөвлөл 418 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байгаагаас Жаргалант суманд 1, сумдад 16 салбар зөвлөлийн ажиллах нөхцөл, орон байр танхимаар хангаж ажиллаж байна. Баянбулаг зуслангаа өргөжүүлэн Баруун бүсийн хүүхдийн зусланг шинээр байгуулж, хичээлээс гадуурх үйл ажиллагаа буюу хүүхэд хөгжүүлэх секц, дугуйлан, сургалтын төвүүдийг дэмжиж, хувь хүний хөгжлийн академи байгуулан ажиллахаар Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан. Хүүхдийн зуслангг MNS 5633:2023-т стандартад нийцүүлэн шинээр байгуулахаар ТЭЗҮ боловсруулахад шаардагдах 200.0 сая төгрөгийг 2026 оны орон нутгийн төсөвт тусгалаа. | | 100 | Хэрэгжсэн |
| 11 | 3.1.3.6. | "Олон нийтийн байцаагч"-ийг ажиллуулж, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлж, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх. | 1.Олон нийтийн байцаагчийн тоо 2. Илрүүлсэн хүүхдийн тоо | - | Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн илрүүлэлт өмнөх оноос 50 хувиар өссөн байна. | Нийгмийн ажилтнууд эрсдэлт нөхцөлд амьдарч буй 827 хүүхдий илрүүлж 628 буюу 75.9 хувьд нь хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлсэн ба илрүүлэлт өмнөх оноос 6 дахин өссөн. Гэмт хэрэг, зөрчлийн гаралт өндөртэй 9 сумдад хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагч ажиллуулж байна. | - | - | Хүүхдийн эрхийн тухай хуулийн 201 дүгээр зүйлд Сум, дүүргийн Засаг дарга баг, хороонд хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагч ажиллуулж болно гэж заасны дагуу сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2025 оны төлөвлөгөөнд Хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагчийн урамшуулал 8.6 сая төгрөгийг тусгууллаа. Мөн гэмт хэрэг, зөрчлийн гаралт өндөртэй Жаргалант, Цэцэг, Булган, Үенч, Алтай, Дөргөн, Манхан, Чандмань, Мөнххайрхан зэрэг 9 сумдад Хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагч ажиллуулж байна. | | 70 | Хэрэгжээгүй |
| **НИЙТ** | | | | | | | | | | | **78.5** | |
| **3.1.4. Хүүхэд хамгааллын талаар:** | | | | | | | | | | | | |
| 12 | 3.1.4.1. | "Хүүхэд хамгааллын бодлого"-ыг сурталчлан таниулж, салбар бүрд мөрдүүлэх; | Хүүхэд хамгааллын бодлого мөрдсөн байгууллагын тоо | - | Орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төр, хувийн хэвшлийн байгууллагын 80 хувьд хүүхэд хамгааллын бодлогыг мөрдүүлсэн байна | Аймгийн хэмжээнд байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөл байгуулсан 133 төрийн болон хувийн хэвшлийн байгууллага байна. Эцэг эхийн зөвлөл байгуулсан байгууллага, аж ахуйн нэгжийн хувь 61,5 болж өмнөх оноос 14,7 хувиар өссөн байна. | 2,1 сая | хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх зардлаас | Хүүхэд хамгааллын бодлогыг байгууллагын ажил үйлчилгээний онцлогт нийцүүлэн боловсруулж мөрдөж буй 95 байгууллага байсан ба тус онд шинээр 14 байгууллага хүүхэд хамгааллын бодлоготой болж, хуулийн хэрэгжилт хангагдаж байна. Хүүхдийн өрөө, тасалгаатай байгууллага 2024 онд 17, 2025 онд 22 болж нэмэгдлээ. Хүүхдийн өрөө тасалгааг тохижуулснаар ажилтан, албан хаагчийн ажлын бүтээмж нэмэгдэж, хүүхдэд учирч болзошгүй эрсдэл багасах үр дүнтэй ажил болсон. Албан байгууллага аж ахуйн нэгжийн дэргэдэх эцэг эхийн зөвлөлөөр дамжуулан төрийн болон төрийн бус байгууллагын 3538 албан хаагчдад гэр бүлийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулж, тэднийг үүрэгжүүлж, хүүхэд хамгааллын бодлогыг нийгмийн бүхийл орчинд хангаж ажиллахыг уриалсан. | | 70 | Хэрэгжсэн |
| 13 | 3.1.4.2. | Орон нутгийн хэмжээнд 2020-2024 онд хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан хүүхэд, үрчлэгдсэн хүүхэд, бүтэн өнчин хүүхдийн нөхцөлд байдалд үнэлгээ хийж, мэдээллийн санд бүртгэх, шаардлагатай хүүхэд хамгааллын үйлчилгээг бүрэн хүргэх; | Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо | - | Хүүхэд хамгааллын үйлчилгээ шаардлагатай хүүхэд бүрд кейс нээж, үйлчилгээг бүрэн хүргэсэн байна. | Эрсдэлт нөхцөлд байгаа 827 хүүхэд байна. Үүнээс бүтэн өнчин 57 хүүхэд байна. Илрүүлсэн 827 хүүхдийн 75.9 хувьд нь хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлж ажилласан ба өмнөх оноос 6 дахин өссөн үзүүлэлттэй байна. | 5.2 сая 22.0 сая | ОНТ, ОУБ хандив тусламж | Аймгийн Засаг даргын бүтэн өнчин хүүхдэд сар бүр олгодог тэтгэмж 2014 оноос эхлэн хэрэгжиж эхэлсэн. Гэрэлт-Ирээдүй хадгаламжид 2024 онд 44 хүүхэд хамрагдсан бол тус онд шинээр бүтэн өнчин 13 хүүхдийн оруулахаар материалыг хүлээн авлаа. Мөн БНХАУ-аас Монгол улсад суугаа Элчин сайд Шэнь Миньжуань Ховд аймагт ажиллах үеэрээ дээрхи хүүхдүүдэд нэрэмжит тэтгэлгээ гардуулсан бөгөөд нийт 22,0 сая төгрөгийн тэтгэлэг олгосон болно. Илрүүлсэн 827 хүүхдийн 75.9 хувьд нь хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлж ажилласан ба өмнөх оноос 6 дахин өссөн үзүүлэлттэй байна. | | 100 | Хэрэгжсэн |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 14 | 3.1.4.3. | Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог шинэчлэн байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, шаардлагатай зардлыг орон нутгийн төсвөөс хуваарилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч хүүхэд бүрд үйлчилгээг бүрэн хүргэх; | 450,292.9 | 1. Орон нутгийн төсвөөс хуваарилсан төсөв, 2. Хууль зүйн хорооны үйлчилгээ авсан хүүхдийн үйлчилгээ авах шаардлагатай нийт хүүхдэд эзлэх хувь | 26.7 хувь | Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос үйлчилгээ авах шаардлагатай хүүхэд бүрд үйлчилгээг бүрэн хүргэсэн байна. | Гэмт хэргийн хохирогч, холбогдогч нийт 37 хүүхэд байгаагаас 16 хүүхдийн асуудлыг хууль зүйн хорооны хурлаар хэлэлцэж 100 хувь үйлчилгээ үзүүлсэн | 1.0 | ОНТ | Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны хурлыг 3 удаа зохион байгуулж, хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 21 ажил хэрэгжүүлэхээр төлөвлөж 90 хувийн биелэлттэй байна. Хороо гэмт хэргийн хохирогч, холбогдогч 37 хүүхдийг хяналтанд авч үйлчилгээ үзүүлсэн бөгөөд 3 удаагийн хурлаар Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 9 хүүхэд, гэмт хэргийн хохирогч 7 хүүхэд нийт 16 хүүхдийн асуудлыг хэлэлцэж 2 хүүхдэд өмгөөллийн үйлчилгээ үзүүлсэн 1 хүүхдийн өмгөөллийн үйлчилгээний 1.0 сая төгрөгийн зардлыг орон нутгийн төсвөөс, 1 хүүхдийн зардлыг хүүхэд хамгааллын зардлаас шийдвэрлэв | | 100 | Хэрэгжсэн |
| 15 | 3.1.4.4. | Хурдан морины уралдаан болон морины сунгаа, уралдааны бэлтгэлийн үед уралдаанч хүүхдийн эрх, амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангаж, хяналт тавих; | | 1.Хяналт, шалгалтын тоо, 2.Илрүүлсэн зөрчлийн шийдвэрлэлтийн хувь | - | Хурдан морины уралдаанч хүүхдийн эрх, аюулгүй байдал 95 хувь хангагдсан байна. | Хаврын бусийн 62 удаагийн уралдаант хяналт шалгалт хийж уралдаанд 1496 хүүхдийн аюулгүй байдлыг хангах, стандартыг мөрдүүлж ажилласан. Шийдвэрлэлт 100 хувьтай. | - | - | Хаврын бусийн 4 уралдаан, түүхт ой, үндэсний их баяр наадмын 58 уралдааны нийт 62 удаагийн уралдаанд 1496 хүүхэд цахим мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдлээ. Уралдаанд оролцогч хүүхэд, уяач, эцэг эхийн хариуцлагын гэрээ, эрүүл мэндийн үзлэг, стандартын хувцас хэрэгсэл, гэнэтийн ослын даатгалд хамрагдалт 100 хувь хийгдэж, уралдааны замын хяналт, хүүхдийн биед авч явахыг хориглосон эд зүйлийг хураан авч эрсдэлд өртөхөөс урьчилан сэргийлэх хяналт шалгалтыг үр дүнтэй зохион байгуулснаар хүүхдийн амь нас, эрүүл мэнд эрсдэлд өртөөгүй. | | 100 | Хэрэгжсэн |
| 16 | 3.1.4.5. | Гамшиг, онцгой байдлын үе, ган зуд, үер усны улмаас хохирсон өрхийн судалгаа, мэдээллийг нэгтгэн гаргаж, салбар дундын хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх; | | 1.Үйлчилгээ авсан өрхийн тоо, хүүхдийн тоо | MNS 6948:2021, шаардлага | Гамшиг, онцгой байдлын үе дэх хүүхэд хамгаалал сайжирсан байна. | Үерт өртсөн 59 өрхөд үнэлгээ хийж, 130 хүүхэд, 32 ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлж, гамшиг, онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж дэмжлэг үзүүлэх журмын дагуу ажиллав. | - | - | 2025 оны 02 сараас эхлэн 17 сум, 12 бөгт хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан ажиллаж эхэлсэнтэй холбогдуулан хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг 2025 оны 06 дугаар сарын 10-ний өдрийн А/94 дугаар тушаалаар шинэчлэн батлуулсан. Мэргэжлийн ангийн 40 пишүүнтэй шинчлэн байгуулж үйл ажиллагааны төлөвлөгөө гарган ажилласан. Төлөвлөгөөнд 12 төрлийн ажил хийхээр тусгасан 85 хувийн биелэлттэй байна. Ховд аймгийн Жаргалант сумын нутаг дэвсгэрт 8 дугаар сард хүчтэй аадар бороо орж Баатархайрхан, Бичигт, Алагголгой, Цамбагарав, Буянт, Наран, Рашаант багийн өрхүүд үерт өртсөн тул харьяа багийн Хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтнууд 59 өрхөд гамшгийн үеийн түргэвчилсэн үнэлгээ, гэр бүлийн нөхцөл байдлын болон хүүхдийн эрсдэлийн үнэлгээ хийж ажилласан. Үнэлгээний дүгнэлтэнд үндэслэн нийт 25 хүүхдэд хичээлийн хэрэгсэл, 22 өрхөд хүнсний дэмжлэг үзүүлсэн. Үерт өртсөн 130 хүүхэд, 32 ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлж, гамшиг, онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж дэмжлэг үзүүлэх журмын дагуу ажиллав. Хүүхдийг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Буянт голын сав газар зусланд гарсан 700 айл өрхийн гэрт эргэн хяналт хийж, гол үер усны аюулаас урьдчилан сэргийлэх 2 төрлийн 750 ширхэг зөвлөмж сэрэмжлүүлэг тарааж, байгууллагын цахим пэйж хуудсанд 5 төрлийн постер байршуулж олон нийтэд хүргэж ажилласан. | | 70 | Хэрэгжсэн |
| 17 | 3.1.4.6. | Хүүхдийн тоглоомын талбай, орон сууцны гэрэлтүүлэг, цахилгаан сүлжээний аюулгүй байдал, замын далан, ухсан нүх, суваг, шуудуу, траншей, худаг орчимд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, шаардлагатай засвар үйлчилгээг хийх, анхааруулах тэмдэг байршуулж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх; | | Осол гэмтлийн буурсан хувь | - | Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгаж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлсэн байна. | Осол гэмтэл гараагүй | - | - | Хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл учрах, хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг аж ахуй нэгж байгууллага, зах худалдааны төвүүд, аймгийн төвийн автобусны 13 буудал, шинээр баригдаж байгаа 21 барилга, 19 авто угаалгын газар, 15 үйлдвэр, зах худалдааны 5 төв, хүүхдийн тоглоомын талбай, дотуур байр зэрэг 73 байршилд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, хүүхдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой 8 төрлийн 78 ширхэг постер, 5 төрлийн 160 гаруй зөвлөмж, тараах материал өгч ажиллав. Эрсдэл учруулж болзошгүй дутагдал арилгах, хууль сахин мөрдөлтийг сайжруулах талаар Улсын байцаагчийн 8 удаагийн зөвлөмж хүргүүлэв. Мөн хүүхэд багачууд, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор Жаргалант сумын 3 байршилд 16 дуут дохиог байрлуулж сургууль, цэцэрлэгийн ойр орчмын замуудад 25 цэгт хүүхдийн аюулгүй байдлыг хангах гэрэлт гарц суурилуулав. | | 100 | Хэрэгжсэн |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 23 | 3.2.2.1. | 2025-2028 онд орон нутгийн хөгжилд ач холбогдолтой, орон нутгийн онцлогтой үйлдвэр, үйлчилгээний салбар, чиглэлийг тодорхойлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ажил олгогчийн судалгааг гаргах, шаардлагатай дэмжлэгийн саналыг боловсруулах; | | 1. Бодлогын баримт бичгийн тоо, 2. Судалгаа, мэдээллийн тоо | Бүсчилсэн хөгжлийн бодлого Засгийн газрын үйл ажиллагааны 2024-2028 оны хөтөлбөр | Судалгаа, шинжилгээний ажлыг хийж, шаардлагатай бодлого, үйл ажиллагааны саналыг боловсруулсан байна. | Аймгийн ИТХ-аар Баялаг бүтээгчдэд хүүгийн хөнгөлөлт үзүүлэх төслийг батлууллаа. | 3.3 тэрбум | ОНТ | Аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн "Баялаг бүтээгч, хувийн хэвшлийн аж ахуй нэгж, бизнес эрхлэгч, малчид тариаланчдыг дэмжих зарим арга хэмжээний" тухай А/01 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангах, өрхийн үйлдвэрлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдийг дэмжих, банкны санхүүжилтээр олгогдож байгаа эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээлүүдэд хүүгийн хөнгөлөлт үзүүлэн бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлж, ажлын байр бий болгох, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор "Баялаг бүтээгчдэд хүүгийн хөнгөлөлт үзүүлэх" хөтөлбөр, журмыг аймгийн ИТХ-ын IV-р хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. Энэхүү хөтөлбөр батлагдсанаар арилжааны банкуудаар дамжуулан 30.0 гаруй тэрбум төгрөгийн зээл олгогдох боломж бүрдсэн. "Баялаг бүтээгчдэд хүүгийн хөнгөлөлт үзүүлэх" хөтөлбөрийн хүрээнд 2025 оны 11 дүгээр сарын 12-ны байдлаар арилжааны 2 банкнаас 6 аж ахуйн нэгж, 13 иргэнд хүүний хөнгөлөлттэй 3,3 тэрбум төгрөгийн зээл олгов. | | 100 | Хэрэгжсэн |
| 24 | 3.2.2.2. | Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгаа хийж, шинээр бий болох ажлын байр, ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтийг нарийвчлан тооцож, хэрэгцээтэй хүний нөөцийн тоо мэдээг салбар, мэргэжил бүрээр гаргах; | | Судалгаа, мэдээллийн тоо | Албан ёсны статистик (Ажиллах хүчний судалгаа) Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний мэдээллийн сан(EJOB систем) | Аймгийн/сум тус бүрээр/ ажилгүйдэл, хөдөлмөр эрхлэлт, ядуурлын тоон мэдээллийн чанар сайжирч, судалгаа, бүртгэл мэдээллийн сан үүссэн байна. | Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгааг ирэх онд мэргэжлийн байгууллагаар дамжуулан хийхээр төлөвлөсөн. | - | - | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгаа хийхээр төлөвлөсөн ба 2026 онд хийхээр төлөвлөн ажиллаж байна. 2025 оны байдлаар Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн ejob программд нийт 1863 иргэн бүртгүүлснээс 807 нь эмэгтэй байна. Үүнээс 15-34 насны залуучууд 1260 буюу 67,6 хувийг эзэлж байна. | | 50 | Хэрэгжээгүй |
| 25 | 3.2.2.3. | Орон нутгийн хүн амын бүлгүүд (эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, оюутан залуучууд зэрэг)-ийн хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, ядуурлын нөхцөл байдлын судалгаа хийх, бүртгэл мэдээллийн сан үүсгэх, онцлог, хэрэгцээнд нь нийцсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | | 1.Аймгийн ажилгүйдэл, ядуурал, хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтийн тооны өсөлт, бууралтын хувь<br>2.Аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилтийн тооны өсөлтийн хувь<br>3.Аймгийн | Хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, ядуурлын үзүүлэлтийн гүйцэтгэл 2023 он - Ажиллах хүчний оролцооны түвшин улсын хэмжээнд 59.5%, хөдөлмөр эрхлэлтийн | Хүн амын бүлэг тус бүрээрх судалгаа хийгдэж, бүртгэл мэдээллийн сан үүсч, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. | 2025 оны 3 дугаар улирлын байдлаар Ажиллах хүчний оролцооны түвшин аймгийн хэмжээнд 64 хувь, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 64.6 хувь, ажилгүйдлийн түвшин 6 хувь 2022 он ядуурлын түвшин хөдөө 35,6 хувь, аймгийн төв 26,1 хувь, сумын төв 30.6 хувь, хөдөө нутаг 41.2 хувьтай байна. | - | - | 2025 оны 3 дугаар улирлын байдлаар Ажиллах хүчний оролцооны түвшин аймгийн хэмжээнд 64 хувь, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 64.6 хувь, ажилгүйдлийн түвшин 6 хувь 2022 он ядуурлын түвшин хөдөө 35,6 хувь, аймгийн төв 26,1 хувь, сумын төв 30.6 хувь, хөдөө нутаг 41.2 хувьтай байна. | | 70 | Хэрэгжсэн |
| 26 | 3.2.2.4. | Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа авдаг хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэний хөдөлмөр эрхлэх, аж ахуй эрхлэх хүсэл сонирхол, санал санаачилгыг бий болгох, дэмжих замаар халамжаас хөдөлмөрт шилжих бодлогын хэрэгжилтийг хангуулах; | | 1.Нийгмийн халамж авагчаас хөдөлмөр эрхлэгч болсон иргэний тоо<br>2.Холбогдох арга хэмжээний тоо<br>3.Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ | 2023 он ДНБ-д нийгмийн тусламжийн зардлын эзлэх хувийн жин 3.7%, /2023 он/ | Аймгийн хэмжээнд халамжаас хөдөлмөрт шилжих бодлого бодитой хэрэгжиж, хөдөлмөр эрхлэлтийн түвшин нэмэгдсэн байна. | Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай 38 өрх санхүүгийн дэмжлэгт хамрагдаж ажил хөдөлмөр эрхлэж байна. | 172,0 | ХЭДС | Халамжаас хөдөлмөрт шилжих бодлогийн хүрээнд нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн иргэнд санхүүгийн дэмжлэг 21 иргэнд 136.3 сая, ХБИ-ний санхүүгийн дэмжлэг 4 иргэнд 23 сая , малжуулах арга хэмжээ 1 иргэнд 8 сая, Байнгын ажлын байр 13 иргэн, сургалт 61 иргэнд 2.7 сая төгрөг тус тус зарцуулсан байна. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин 64.6 буюу өмнөх онтой харьцуулахад 3.9 хувиар өссөн байна. | | 70 | Хэрэгжсэн |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 30 | 3.2.2.8. | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжилт авсан ААНБ, иргэдийн бараа бүтээгдэхүүнд борлуулалтын дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг шинэ түвшинд гаргаж, арга барилыг сайжруулж шинэчлэх, томоохон ААНБ-тай гэрээ байгуулж, борлуулалт хийх, хамтран ажиллах; | | 1.Борлуулалтын дэмжлэгт хамрагдсан хүний тоо,<br>2.Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ | 2023 онд ХЭДС-аас борлуулалтын дэмжлэгт 460 хүн хамрагдаж 341,3 сая төгрөг зарцуулсан. | ХЭДС-аас санхүүгийн дэмжлэг, жижиг зээл авсан иргэн, аж ахуйн нэгжийн борлуулалтын дэмжлэгийн арга хэмжээ төрөлжин нэмэгдэж, хамрагдагсдын тоо, борлуулалтын хэмжээ нэмэгдсэн байна. | 2025 онд ХЭДС-аас борлуулалтын дэмжлэгт 235 хүн хамрагдаж 38,0 сая төгрөг зарцуулсан. | 38,0 | ХЭДС | Энэ жилийг Баялаг бүтээгчдийг дэмжих жил болгон зарласан. Энэ хүрээнд Сар шинийн баярыг угтсан Ховдод үйлдвэрлэв үзэсгэлэн худалдаа арга хэмжээг "Ховдод үйлдвэрлэв" борлуулалтын төвд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчлан борлуулж, орхийн орлогыг нэмэгдүүлэх, иргэд олон нийтийг сар шинийн баярын бараа бүтээгдэхүүнээ нэг дороос өргөн сонголттой, хямдралтай сонгон үйлчлүүлэх боломжоор хангах зорилготой үзэсгэлэн худалдааг хоёр үе шаттай зохион байгууллаа. 2025 оны 2 дугаар сарын 5-ний өдрөөс 21-ний өдөр хүртэл хөдөөгийн сумдын болон аймгийн төвийн 150 гаруй иргэд, аж ахуй нэгжийн 286 нэр төрлийн бараа бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа бүсчилсэн байдлаар зохион байгуулагдаж 24,9 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн байна.<br>Харин сар шинийн баярт зориулсан нэгдсэн үзэсгэлэн худалдаа хоёрдугаар сарын 24-26-ний өдрүүдэд Биеийн тамир спортын төв ордонд зохион байгуулсан. Тус арга хэмжээнд 115 гаруй баялаг бүтээгч аж ахуй нэгж, иргэд оролцож өөрсдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээ борлуулж нийт 231,540,000 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. | | 100 | Хэрэгжсэн |
| 31 | 3.2.2.9. | Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, дүүргийн зөвлөлийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах; | | Холбогдох арга хэмжээний тоо | 2023 онд ХЭДС-аас хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн үйл ажиллагаар дэмжихэд 160.7 сая төгрөг зарцуулсан. | Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн үйл ажиллагаа өргөжиж, нийгмийн түншүүдтэй хамтран хэрэгжүүлэх арга хэмжээ нэмэгдсэн байна. | Гараан бизнес эрхлэгчдийн дэмжих Старт ап арга хэмжээг 2 удаа зохион байгууллаа. | 30.0 | ОНТ | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих салбар зөвлөлийн хурлын шийдвэрээр залуучуудын гараан бизнесийг дэмжих старт ап арга хэмжээг Старт ап Монгол төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулж Засаг даргын Тамгын газраас 2 шилдэг төсөлд 20.0 сая төгрөгийн буцалтгүй санхүүжилтийг олголоо. Мөн салбарын хэмжээнд 2025 оныг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан "Хамгийн сайн халамж-Хөдөлмөр эрхлэлт" Старт апп арга хэмжээг зохион байгуулж Хөгжлийн бэрхшээлтэй гараан бизнес эрхлэгч 2 залууд буцалтгүй 10.0 төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн. Аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/237 дугаар захирамжаар Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийг шинэчлэн байгуулсан бөгөөд зөвлөлийн анхны хуралдааныг 2025 оны 05 дугаар сард Засаг даргын арын өрөөнд зохион байгуулсан. Хурлын үеэр 2024 онд хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан, 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг танилцуулж санал авч батлуулсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, үйл ажиллагааны хүрээнд нийт 428 иргэнийг хөтөлбөр арга хэмжээнд хамруулж 1.6 тэрбум төгрөгийн эргэн төлөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг олгож 343 шинэ ажлын байр шинээр бий болгосон. Мөн эргэн төлөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг олгох сонгон шалгаруулалтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн гишүүдийг оролцуулан ажиллуулж, шалгаруулалтын ил тод, шударга байдлыг хангаж зохион байгууллаа. | | 100 | Хэрэгжсэн |
| 32 | 3.2.2.10. | Хөдөлмөрийн тухай хуулийн 144.3, 145.4 дахь заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 43.3 дахь заалт, Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангуулж, төвлөрсөн хөрөнгийг орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилгүйдлийг бууруулах үйл ажиллагаанд зориулалтын дагуу зарцуулах | | 1.Төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ<br>2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгийн хэмжээ<br>3.Бий болсон ажлын байр, ажилд зуучлагдсан хүний тоо | 2023 онд ХЭДС-нд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй ажлын байрны төлбөрөөс 6.9 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн. | Аймгийн хэмжээнд орлого төвлөрүүлэлт нэмэгдэж, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настны хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна. | Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангахаар 3 аж ахуйн нэгж, байгууллагаас 85.0 сая төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн дансанд төвлөрүүлэн ажилласан. | 85.0 | ХЭДС | Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангах хүрээнд 25 ваас дээш ажилтантай ААН-ийн судалгааг гарган мэдээллийн сан үүсгэсэн бөгөөд 140 байгууллага 402 ХБИ ажиллуулах ёстойгоос 308 ХБИ-ийг ажиллуулж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй 55 аж ахуйн нэгж, байгууллагад мэдэгдэх хуудас хүргүүлж 3 аж ахуйн нэгж, байгууллагаас нийт 85.0 сая төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлэн ажилласан. 2025 оны төлөвлөгөөгөөр 64.0 сая төгрөгийн төлбөр төвлөрүүлэхээс 31.0 сая төгрөгийн орлого илүү төвлөрүүлэн ажилласан. | | 100 | Хэрэгжсэн |
| НИЙТ | | | | | | | | | | | | 85 | |
| 3.2.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар: | | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 33 | 3.2.3.1. | Орон нутгийн түвшинд үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгааныг судалж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг төсөвлөн, зарцуулах, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төрийн захиргааны хяналтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | ХАБЭА-н тухай хуулинд заасан шаардлагыг хангасан эсэх. | 2024 оны хэрэгжилт | Хуульд заасан хэмжээнд хүргэсэн байна. | 2025 онд бүртгэгдэж хянан баталгаажуулсан үйлдвэрлэлийн ослын шалтгаан нөхцөлийг тогтоож ангилахад хүний үйл ажиллагаатай холбоотой 50 %, техник тоног төхөөрөмжтэй холбоотой 30%, ажлын байр орчинтой холбоотой 15%, байгаль цаг ууртай холбоотой 5% байгаа бөгөөд ажилтан хүн ажлын байранд ажил үүргээ гүйцэтгэж байхдаа үйлдвэрлэлийн осолд өртөх тохиолдол нийт ослын 100% -ийг эзэлж байна . Орон нутгийн төсвөөс 8.0 сая төгрөгийг шийдвэрлэж урьдчилан сэргийлэх арга хэмжээний үйл ажиллагаанд зарцуулсан байна. | | | ХАБЭА-н салбар хорооны гишүүдийг чадавхжуулах сургалтыг 16 сумын 118 гишүүнийг хамруулан Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч болон хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч нар хамтран цахим хэлбэрээр зохион байгуулсан. Мөн 2025 онд Буянт, Жаргалант, Мянгад, Зэрэг, Дарви, Цэцэг сумдад хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зөвлөл болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх комиссыг чадавхжуулах хүрээнд сургалт зохион байгуулан гарын авлага, тараах материалаар хангаж ажилласан байна. | | 70 | Хэрэгжсэн |
| 34 | 3.2.3.2. | Аймаг, дүүргийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, хувиараа, албан бус хөдөлмөр эрхлэгч, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, малчдыг үйлдвэрлэлийн осол, аюултай, хортой хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах, сэрэмжлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | 1.Төлөвлөсөн төсөв<br>2. Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2024 оны гүйцэтгэл | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Аймгийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөл 2026 онд 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 9 арга хэмжээ 100 хувьтай хэрэгжиж хэрэгжилт 75 хувьтай байна. | 20.0 сая | ОНТ | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийн төлөвлөгөөнд тусгагдсан 9 арга хэмжээ зохион байгуулсан. Ховд аймгийн 16 сумын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зөвлөлийн 118 гишүүнийг хамруулан Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч болон хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч нар хамтран цахим хэлбэрээр хурал зохион байгуулсан. Тус хурлаар Хөдөлмөрийн гэрээнээс бусад төрлийн гэрээгээр ажил, үүрэг гүйцэтгэгч, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч болон хувиараа хөдөлмөр эрхлэгч, хоршоо, нөхөрлөлийн гишүүн хөдөлмөр эрхлэх явцад үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн тохиолдолд тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулсан (Засаг даргын Тамгын газраас нэг, ажил олгогч болон ажилтны төлөөллөөс тус бүр хоёр хүний бүрэлдэхүүнтэй) комисс тухайн гарсан осол, хордлогыг судлан бүртгэж, акт тогтоох процесс ажиллагааг тайлбарлан таниулж хууль болон түүнийг дагаж гарсан журмыг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөгөө мэдээлэл өгсөн. Мөн Буянт, Жаргалант, Мянгад, Зэрэг, Дарви, Цэцэг сумдад хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зөвлөл болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх комиссыг чадавхжуулах хүрээнд сургалтыг танхимаар зохион байгуулж гарын авлага, тараах материалаар хангаж ажилласан байна. | | 70 | Хэрэгжсэн |
| 35 | 3.2.3.3. | Хүний эрүүл мэнд, амь насанд ноцтой хохирол учруулсан үйлдвэрлэлийн томоохон осол, хурц хордлогын үед түүний хор уршгийг арилгах, хүн амыг яаран хамгаалахад чиглэгдсэн шуурхай арга хэмжээг авах. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | 1.Төлөвлөсөн төсөв<br>2.Тухай бүр авсан арга хэмжээний тоо | 2024 оны гүйцэтгэл | Тухай бүр арга хэмжээ авсан байх | Үйлдвэрлэлийн осолд өртсөн 16 ажилтны ослын актыг хянан баталгаажуулж осолдогч нийгмийн хамгааллын үйлчилгээг шуурхай авах тал дээр анхаарч ажилласан. Ослын дуудлага мэдээллийн дагуу Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газрын Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын ахлах байцаагч, хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч нар ослын газар дээр ажиллаж, ослын шалтгаан нөхцөлийг судалж, дахин осол гарахаас урьдчилан сэргийлж тоног төхөөрөмжийн үйл ажиллагааг зогсоох акт гаргасан. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 20.0 сая төгрөг тусган холбогдох үйл ажиллагаанд зарцуулсан. | | ХХҮГ төсө | 2025 оны жилийн эцсийн байдлаар үйлдвэрлэлийн осол 16 бүртгэгдэж 16 ослын актыг хянаж баталгаажуулан цахим системд бүртгэсэн. Үүнээс бүлэг осол 2 гарсан байна. Осолдогчдыг хүйсээр нь авч үзвэл 92,6% эрэгтэй, 7,4% эмэгтэй бөгөөд үхэлд хүргэсэн тохиолдол 22,2%, үхэлд хүргээгүй 77,8% байна. Үйлдвэрлэлийн осол гарсан орчин нөхцөлийн хувьд үйл ажиллагааны талбайд буюу ажлын байрандаа ажил үүргээ гүйцэтгэж байх үед осолдсон тохиолдол 100% байна . Үйлдвэрлэлийн осолд өртсөн 27 ажилтны ослын актыг хянан баталгаажуулж осолдогчийн нийгмийн баталгааг хангаж ажилласан. Ослын газарт нэг бүрчлэн ажиллаж ослын шалтгаан нөхцөлийг тодруулж зөрчил арилгах хугацаатай албан шаардлага 2, үйл ажиллагаа зогсоосон акт 2, үйл ажиллагааг сэргээсэн акт 2, дүгнэлт 2 гаргаж ажиллаж байна. Аж ахуй нэгжид үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх талаар нийт ажилтаны сургалтыг 6 байгуулллагад, ажил хөдөлмөр эрхэлж буй ажилтан, ажил олгогч нарт зориулсан геёв 4 -ийг бүтээж олон нийтэд түгээж ажилласан . | | 70 | Хэрэгжсэн |
| | | | | | | | **НИЙТ** | | | | | 70 | |
| | | | | | | | **3.2.4. Ажиллах хүчний шилжилт, хөдөлгөөний талаар:** | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 36 | 3.2.4.1 | Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авсан тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ажил олгогчтой бүртгэлтэй ажилгүй иргэнийг ажлын байранд дагалдуулан сургах, ажлын байраар хангах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | 1.Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлөөр ажиллаж байгаа гадаад ажилтны тоо 2.Гадаад ажилтны ажлын байрны төлбөрийн орлогын хэмжээ 3.Гадаад ажилтан ажиллуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын монгол, гадаад ажилтны тоо хэмжээний харьцааны өөрчлөлт3.Гадаад ажилтан ажиллуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын монгол, гадаад ажилтны тоо хэмжээний харьцааны өөрчлөлт | 2024.12.15 байдлаар: Орон нутагт хөдөлмөр эрхлах зөвшөөрлөөр ажиллаж байгаа гадаад ажилтны тоо 8.1 мянган хүн | Аймгийн хэмжээнд ажилгүйдэл буурч, хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна. | 2025 онд 4 аж ахуй нэгж байгууллагын нарийн мэргэжлийн ажиллах хүчин авах 113 хүсэлтийг уламжлан ажилласан байна. | - | - | Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 3.1.2 заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 4.2 заалт, дүрэм, журам, зааврыг хэрэгжүүлэн 2025 онд 4 аж ахуй нэгж байгууллагын нарийн мэргэжлийн ажиллах хүчин авах 113 хүсэлтийг уламжилсан. | | 100 | Хэрэгжсэн |
| 37 | 3.2.4.2. | Гадаад ажилтнаар хөдөлмөр эрхлүүлж байгаа ажил олгогчид зөвлөгөө өгөх, гадаад ажилтны хөдөлмөр эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн нөхцөл, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалтыг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | | | Хуулийн хэрэгжилт сайжирсан байна. | Хяналт шалгалтаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт 53,5 хувьтай, их эрсдэлтэй 1, дунд эрсдэлтэй 1 байна. | - | - | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 08-07/16 тоот төлөвлөгөөт бус хяналт шалгалтын удирдамжаар Ховд аймагт гадаадаас ажиллах хүч, ажилтан авч ажиллуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудад Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартын хэрэгжилтэд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, холбогдох хяналтын хуудсаар эрсдэлийн болон хууль сахин мөрдөлтийн түвшинг тогтоож, гадаад улсын иргэдийг хүн худалдаалах болон албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэрэг, болзошгүй осол гэмтэл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. "Хөдөлмөрийн харилцааг шалгах хяналтын хуудас"-аар-"Пауер констракшн корпорайшн оф Чайна" ХХК 340 оноо буюу 69%, "Их", Талст Молор ХХК 255 оноо буюу 51%, "Их" эрсдэлтэй тус тус шалгагдаж Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт 60 хувьтай, их эрсдэлтэй 2 байна. 8.2 07.1.2 кодтой "Хөдөлмөрийн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас"-аар-"Пауер констракшн корпорайшн оф Чайна" ХХК 370 оноо буюу 67% "Их", Талст Молор ХХК 290 оноо буюу 40% "дунд" эрсдэлтэй тус тус шалгагдаж Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт 53,5 хувьтай, их эрсдэлтэй 1, дунд эрсдэлтэй 1 байна.<br>Талст Молор ХХК болон Алтайн бөөрөг ХХК-ажлын байрны төлбөрөө хуульд заасан хувь хэмжээгээр төлсөн бол Пауер констракшн корпорайшн оф Чайна ХХК-Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр хөнгөлөлт | | 50 | Хэрэгжсэн |
| НИЙТ | | | | | | | | | | | | 75 | |
| 3.3. Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Ахмад настны тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд дараах арга | | | | | | | | | | | | | |
| 3.3.1. Нийгмийн даатгалын талаар: | | | | | | | | | | | | | |
| 38 | 3.3.1.1. | Орон нутгийн иргэдэд нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх замаар малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, залуучуудыг нийгмийн даатгалд хамруулах ажлыг Нийгмийн даатгалын байгууллагатай хамтран зохион байгуулах; | | Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагчийн тооны өсөлтийн хувь | Улсын хэмжээнд сайн дураар даатгуулагчийн тоо 2023 он-152 800 | Сайн дураар даатгуулагчийн тоог 10-аас багагүй хувиар нэмэгдүүлсэн байна. | Сайн дураар даатгуулагч өмнөх оны мөн үеэс 10 хувиар буюу 430 даатгуулагчаар өссөн байна. | - | - | 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 5040 хүнийг сайн дурын даатгалд хамруулсан. | | 100 | Хэрэгжсэн |
| 39 | 3.3.1.2. | Нийгмийн даатгалын үйлчилгээг аймаг, дүүргийн иргэдэд шуурхай хүргэх зорилгоор нийгмийн даатгалын цахимжуулалтыг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэх; | | Цахим хэлбэрт шилжүүлсэн тэтгэврийн хувийн хэргийн эзлэх хувь | - | Тэтгэвэр авагчдын хувийн хэргийг цахимжуулах ажлын хүрээнд тэтгэвэр авагчдын хувийн хэргийг 100% цахим хэлбэрт шилжүүлсэн байна. | Тэтгэвэр авагчдын хувийн хэргийг 100 хувь цахим хэлбэрт шилжүүлсэн байна. | - | - | Тэтгэвэр авагчдын хувийн хэргийг 100 хувь цахим хэлбэрт шилжүүлсэн байна. | | 100 | Хэрэгжсэн |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 40 | 3.3 1.3. | Даатгуулагчийн нийгмийн баталгаа хангах хүрээнд ажил олгогч хуулиар хүлээсэн эрх, үүргээ биелүүлж, нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүсгэхгүй байх, өр үүссэн тохиолдолд нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг шуурхай барагдуулахад Нийгмийн даатгалын байгууллагатай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх; | ######## | Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй төсөвт байгууллагын тоо | Улсын хэмжээнд өртэй төсөвт байгууллагын тоо - 848 | - | 2024 онд нийт 23 төсөвт байгууллагын 107.9 сая төгрөгийн авлага бүрэн төлөгдсөн. | - | - | 2024 оны төсөвт байгууллагын 107.9 сая төгрөгийн авлага бүрэн төлөгдсөн. | | 100 | Хэрэгжсэн |
| 41 | 3.3.1.4. | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй үйлчлүүлэх нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах, хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэхэд эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах; | | Хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоо | Улсын хэмжээнд хөдөлмөрийн чадвар алсан иргэдийн тоо 102446 | Хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоог 25 хувиар бууруулсан байна. | Хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоо 2665 болж, 2 хувиар бууруулсан байна. | - | - | Хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоо 2024 онд 2717, 2025 онд 2665 иргэн болж 2 хувиар бууруулсан байна. | | 100 | Хэрэгжсэн |
| 42 | 3.3.1.5 | Хуримтлалын сангийн үйл ажиллагаатай холбогдуулан орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх, холбогдох тооцоо судалгаа хийхэд хамтран ажиллах. | | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | Хуримтлалын сангийн үйл ажиллагаатай орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх, холбогдох тооцоо судалгаатай болсон байна. | Тооцоо судалгаа хийгдэж байна. | - | - | Аймаг орон нутгаас төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөрийн 1 дүгээр үе шатыг зарим сумдад хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийн хөрөнгийг бүсчлэн шийдвэрлэж, Ховд аймгийн Булган, Чандмань, Дарви, Зэрэг сумдад 8–15 айлын орон сууцны хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэгдсэн. Үүнээс Дарви-8 айл, Булган-15 айлын барилга угсралтын ажил эхэлсэн. | НДЕГ-т тооцоо судалгаа хийгдэж байгаа | 50 | Хэрэгжсэн |
| НИЙТ | | | | | | | | | | | | 90 | |
| 3.3.2. Нийгмийн халамжийн талаар: | | | | | | | | | | | | | |
| 43 | 3.3.2.1. | Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах үйлчилгээнд согтууруулах, мансууруулах бодис хэрэглэдэг өрхийг хамруулах; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Үйлчилгээнд хамрагдсан хүний тоо, үүнээс хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг өрхөөс шинээр хөдөлмөр эрхэлсэн иргэний тоо | - | Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэдийг орлогын эх үүсвэртэй болгох, амьдрах ухаанд сургах үйлчилгээнд хамруулсан байна. | Төндэрийн үндсэн шалгуур үзүүлэлт хангасан байгууллага гараагүй | - | - | Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний чанарт тавигдах шалгуур, үйлчилгээ үзүүлэх журам, гэрээний загвар, үйлчилгээний өртөлөл, заавар, үнэ тариф зэрэг баримт бичгүүдийг шинэчлэн баталсныг сумдын хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд, төндерт оролцох хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагуудад хүргэн ажиллаж байна. | | 50 | Хэрэгжсэн |
| 44 | 3.3.2.2 | Орон гэргүй эсхүл архинд донтсон иргэдийг нийгэмшүүлэх, донтолтоос ангижруулах арга хэмжээг орон нутагтаа холбогдох талуудыг оролцуулан зохион байгуулах, архинаас гаргах дэмжих бүлгүүдтэй хамтран ажиллах; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Дэмжих бүлгийн тоо, архинаас гарсан иргэний тоо, үүнээс хөдөлмөр эрхэлж тогтмол ажлын байртай болсон хүний тоо | - | Орон гэргүй эсхүл архинд донтсон иргэдийг нийгэмшүүлэх, донтолтоос ангижруулах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. | Төндэрийн үндсэн шалгуур үзүүлэлт хангасан байгууллага гараагүй | - | - | Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Бусийн оношилгоо эмчилгээний төвийг түшиглэн "Жаргалтай амьдрал" төвийг байгуулж, зорилтот бүлгийн иргэдийг хорт зуршлаас салгах, нийгэмд идэвхтэй иргэн болгон төлөвшүүлэх зорилт тавин 2026 онд төсөвт 100.0 сая төгрөгийг тусгаад байна. | | 50 | Хэрэгжээгүй |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 45 | 3.3.2.3. | Нийгмийн ажилтнуудын бусад салбарын ажилтнуудтай хамтран ажиллах ажлын уялдаа холбоог сайжруулах, чадавхжуулах сургалтад тогтмол хамруулах. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | 1.Хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо. | - | Нийгмийн ажилтнуудын мэдлэг ур чадвар сайжирсан байна. | Шинээр томилогдсон Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнуудыг ажиллах орчин нөхцлөөр хангаж, тоног төхөөрөмж , 2 удаа чадавхжуулах сургалтанд хамруулж, орон нутгийн төсвөөс 38.6 сая төгрөгийн 30 таблет, аюулгүй ажиллагааны багцийн дэмжлэг үзүүлж, ажиллах орчин нөхцөлийг сайжруулсан. | 38.6 сая | ОНТ | Нийгмийн ажилтнуудыг чадавхжуулах сургалтын хөтөлбөрийг 4 зорилт, 12 арга хэмжээний хүрээнд боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Сумын хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд, Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнуудыг чадавхжуулах 2 удаагийн сургалт, Ёс зүйн чиглэлээр 3 удаагийн сургалт, Авлигын эсрэг хууль, Зөрчлийн тухай хууль, Хүний эрхийн үндсэн ойлголт, Жендерийн төлөв байдал сэдвээр тус бүр 1 удаагийн сургалт, арга хэмжээг зохион байгуулсан. Шинээр томилогдсон Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнуудыг ажиллах орчин нөхцлөөр хангаж, орон нутгийн төсвөөс 38.6 сая төгрөгийн 30 таблет, аюулгүй ажиллагааны багцийг хүлээлгэн өгч, ажиллах орчин нөхцөлийг сайжруулсан | | 100 | Хэрэгжсэн |
| НИЙТ | | | | | | | | | | | | 66.6 | |
| 3.3.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн таатай: | | | | | | | | | | | | | |
| 46 | 3.3.3.1. | Хөгжлийн бэрхшээлийн талаарх олон нийтийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах; | | Сургалт | - | 30-аас доошгүй | Хөгжлийн бэрхшээлийн талаарх олон нийтийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэх 106 удаагийн сургалт, арга хэмжээг зохион байгуулсан. | 4,4 | ОНТ | Хөгжлийн бэрхшээл болон хүртээмжтэй орчин, хууль тогтоомж, тэмдэглэлт өдрүүд, онцлог арга хэмжээний хүрээнд нөлөөллийн 73 контент хийж, холбогдох байгууллагуудын пейж хуудсаар түгээснээр 1 контентийн дундаж хандалтын тоо 4 мянгад хүрсэн байна. Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт мэдлэг олгох 16 удаагийн сургалтыг боловсролын байгууллага болон иргэд, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид зохион байгуулж нийтдээ 929 хүн хамрагдсан байна. ХБХХТ-ийн явуулын үйлчилгээний баг нийт 17 суманд нийгмийн сэтгэл зүй болон сэргээн засах, тусламж үйлчилгээг 832 иргэнд үзүүлж, сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгууллаа. | | 100 | Хэрэгжсэн |
| 47 | 3.3.3.2. | Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах; | ######## | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | | 20 | Хөгжлийн бэрхшээлийн иргэдийн улс төрийн эрхийг хангах, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран 10 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан. | - | - | Шийдвэр гаргах түвшинд ажиллаж байгаа Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл хангалтгүй байна. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн дунд хөгжлийн бэрхшээлтэй иргэний төлөөлөл 2024 оны орон нутгийн сонгуульд сонгогдоогүй. Сумдын Иргэдийн хурлын 367 төлөөлөгчөөс 4 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна. Аймгийн Иргэдийн хурлын 41 төлөөлөгчдөөс 7 буюу 17, Сумын Засаг дарга нараас 1 буюу 5.8, Тамгын газрын дарга 7 буюу 38.8 хувийг эмэгтэй удирдах албан тушаалтан эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлийн иргэдийн эрхийг хангах, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран 10 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан. | | 50 | Хэрэгжсэн |
| 48 | 3.3.3.3. | Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох сургагч багш бэлтгэн, орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургалтад хамруулах; | | Зохион байгуулсан сургалтын тоо | - | 3 | Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг 2 удаа зохион байгуулсан. | - | - | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг бэлгийн хүчирхийллийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй 31 иргэдэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулж эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд хамрагдаагүй сонсголын бэрхшээлтэй 7 иргэнийг үзлэгт хамруулсан. Өсвөрийн кабинетаар 2025 оны 10 сарын байдлаар нийт 5963 өсвөр насны хүүхдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ авснаас хөгжлийн бэрхшээлтэй өсвөр насны 13 хүүхдүүдэд тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Ерөнхий боловсролын сургуулиуд болон Политехник коллежийн нийт 499 оюутан, сурагчдад "Бэлгийн бойжилт", "Хорт зуршил", "Бэлгийн замаар дамжих халдвар", "Бэлгийн хүчирхийлэл", "Өсвөр насны охидын эрүүл мэнд", "Хүүхдийн эрх ба үүрэг", "Жендерийн тухай ойлголт" сэдвүүдээр эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, сурталчилгаа зохион байгуулж, мэдээлэл, зөвлөгөө өгсөн. | | 63 | Хэрэгжсэн |
| 49 | 3.3.3.4. | Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх дэмжих төвийг байгуулах; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Дэмжих төв | - | 1 | Энэхүү үйлчилгээг үзүүлэх шалгуурыг хангах магадлан итгэмжлэгдсэн орон нутгийн ТББ байхгүй байна. 2026 оноос Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ТББ түшиглэн нэвтрүүлэхээр төлөвлөсөн. | - | - | Энэхүү үйлчилгээг үзүүлэх шалгуурыг хангах магадлан итгэмжлэгдсэн орон нутгийн ТББ байхгүй байна. 2026 оноос Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийг холбоог чадавхжуулж орон байрны дэмжлэг үзүүлж, бусад шалгуур шаардлагыг хангуулан тус үйлчилгээг нэвтрүүлэхээр төлөвлөсөн. Мөн Жей Си Эс олон улсын байгууллагатай хамтран Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан эрүүл, аюулгүй орчинд сурч хөгжих " Хөвд- Хүүхэд , олон нийтийн хөгжил төсөл" хэрэгжүүлэхээр газрын асуудлыг шийдвэрлэн бэлтгэл хангаж ажиллаж байна. Төслийн хүрээнд хүүхдийн хөгжлийн анги танхимууд, өдөр өнжүүлэх төв, тоглоомын талбай, Аутизмтай хүүхдүүдэд зориулсан тоглоомын талбай зэрэг иж бүрэн төлөвлөлт хийгдэж, ирэх оноос хэрэгжиж эхлэнэ | Энэхүү үйлчилгээг үзүүлэх шалгуурыг хангах магадлан итгэмжлэгдсэн орон нутгийн ТББ байхгүй байна. | 50 | Хэрэгжсэн |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 50 | 3.3.3.5. | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлэх; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | - | 2 | ХБХЭМБНХСК-ийн шийдвэрээр 3 арга хэмжээг хэрэгжүүлсэн. | 12.4 | ОНТ | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хурал 20 удаа хуралдаж,172 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудлыг хэлэлцэж 57 хүүхэд шинээр хөгжлийн бэрхшээлийг тогтоож, 93 хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн шийдвэрийг 12,24, 36 саруудаар сунгалт хийж, 11 хүүхдийн биеийн байдал сайжирсан тул хөгжлийн бэрхшээлийн шийдвэрийг цуцалж, 50 хүүхэд 16 нас хүрсэн тул байнгын асаргааны тэтгэмжийг цуцалсан ээжэн халамжийн тэтгэмжийг 18 нас хүртэл сунгалт хийж ажилласан. 1. Тархины саа саажилт, аутизмын хүрээний эмгэг, уналт таталт зэрэг оноштой байнгын асаргаанд байдаг 0-18 насны 88 хүүхдийг эцэг эх, асран хамгаалагчдын хамт "Эх Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв"-ийн нарийн мэргэжлийн эмч нарын цогц үзлэг шинжилгээнд хамруулсан. Энэ үйл ажиллагаанд шаардагдах 9.4 сая төгрөгийн зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлэсэн. 2.Зуны чийрэгжүүлэлтийн үйлчилгээнд орон нутгийн төсвөөс 3.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн тархины саажилттай байнгын асаргаатай, дархлаа сул, ханиад томуунд өртөмтгий 21 хүүхдийг сувилалд хамруулснаар эрүүл мэндийн байдал нь сайжирч, жин нэмэгдсэн зэрэг үзүүлэлтүүд гарсан байна. 3. 2024-2025 онд сайн дурын нийгмийн даатгалд 124 эцэг эх, асран хамгаалагч нарыг хамруулсан. Эрүүл мэндийн үйлчилгээ 18,36 сартай эрт илрүүлэг үзлэгт 18 сартай 817 хүүхдийн 45% буюу 367 хүүхэд,36 сартай 921 хүүхдийн 36% буюу 322 хүүхэд үзлэгт хамрагдсан. | | 100 | Хэрэгжсэн |
| 51 | 3.3.3.6. | Орон нутгийн гамшгаас хамгаалах, онцгой байдлын үед авах арга хэмжээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ шаардлагыг тусган боловсруулж, хоргодох байрны хүртээмжийг нэмэгдүүлэх | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Арга хэмжээний хэрэгжилтийн хувь | - | 100 | Орон нутгийн гамшгаас хамгаалах, онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөө 93 хувийн хэрэгжилттэй байна. | - | - | Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг чадавхжуулах, тэдэнд мэдээлэл өгөх чиглэлээр 3 үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлсэн байна. "Гамшгийн үеийн арга хэмжээ болон гамшгаас урьдчилан сэргийлэх" чиглэлээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг чадавхжуулах сургалтанд 32 иргэнийг хамруулж, аймгийн хэмжээнд сургууль, цэцэрлэг, соёлын төв, спорт заал, барилгуудыг сонгон 57 хоргодох байрыг төлөвлөж, 2 цэцэрлэг, 7 сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэхээр ТЭЗҮ боловсруулах зардлыг 2026 оны аймгийн төсөвт тусган шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. | | 93 | Хэрэгжсэн |
| 52 | 3.3.3.7. | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчийн хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, хүүхдээ нийгмийн идэвхтэй гишүүн болгоход чиглэсэн чадавхжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | 5 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдэд зориулсан сургалт, бүлгийн уулзалт ээлжээр 16 удаа зохион байгууллаа. | 2.0 сая | ОНТ | Мэргэшсэн хэл засалч АУ-ны магистр Ц.Сумангэрэлтэй хамтран хэл ярианы хөгжлийн дэмжлэг үзүүлэх арга зүйд 7 ЕБС, 16 цэцэрлэгийн 40 багш, мөн 40 эцэг, эх асран хамгаалагчдыг сургаж дадлагажуулаа. Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт мэдлэг олгох 16 удаагийн сургалтыг боловсролын байгууллага болон иргэд, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид зохион байгуулж нийтдээ 929 хүн хамрагдсан байна.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдэд зориулсан сургалтыг 7 удаа, бүлгийн уулзалтыг 5 удаа зохион байгуулан, туршлага солилцсон байна. Эцэг эхчүүдэд зориулсан ганцаарчилсан уулзалт, сэтгэл зүйн үйлчилгээнд давхардсан тоогоор 256 хүн хамрагдсан байна. | | 100 | Хэрэгжсэн |
| 53 | 3.3.3.8. | Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх ажлыг Төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулах; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Гэрээ байгуулан хамтран ажилласан ТББ-ын тоо | - | 3 | Ховд аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн "Найдварын түүчээ холбоо", Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоотой төрийн бус байгууллагатай төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна. | - | - | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, Хөгжлийн Бэрхшээлтэй хүүхдүүд болон тэдний эцэг эх гэр бүлийг чадавхжуулах, эцэг эхчүүдийн сайн дурын нэгдлийг бэхжүүлэх, тэдэнд эрүүл мэнд боловсрол хөгжлийн цогц үйлчилгээ үзүүлэх зорилгоор Ховд аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн "Найдварын түүчээ холбоо", Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоотой төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна. 2024 онд 31.6 сая төгрөгийн ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулан ажиллаж гэрээний биелэлт 91 хувьтай үнэлэгдсэн байна. Тайлант онд 42.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан бөгөөд гэрээ дүгнэх хурлыг 12 дугаарсард багтаан хийхээр төлөвлөсөн. | | 100 | Хэрэгжсэн |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 54 | 3.3.3.9. | Орон нутгийн цахим хуудас, телевиз, нийгмийн мэдээллийн хэрэгслийн хүртээмжийг сайжруулах; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Хүртээмжтэй хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, цахим хуудасны тоо | - | 5 | Орон нутгийн 4 хэвлэл мэдээллийн хэрэгсэл, 2 байгууллагын цахим хуудас хүртээмжээ сайжруулллаа. | 2.0 сая | ОНТ | Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 6 хэвлэл мэдээллийн байгууллагын удирдлага, ажилтнуудтай уулзалт зохион байгуулсны үр дүнд Newkhovd.mn, Khovdtimes.mn, Ховд.мн, Ховд ТВ, мөн баруун бүсийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болох "Баруун хязгаар" сайтуудаар нийт хадмал орчуулгатай 9 мэдээ бэлтгэн олон нийтэд хүргэсэн.<br>Нийтлэгдсэн мэдээнүүдийн хандалт нэг удаагийн буюу шууд үзэлтээр 4.0–5.5 мянга, давхардсан тоогоор 32.8 мянга гаруй иргэн мэдээлэл авч үзсэн нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн мэдээллийн хүртээмж, нийгмийн оролцоо хандлагыг нэмэгдүүлэхэд бодитой хувь нэмэр үзүүлсэн. Мөн "Ахиллис" олон улсын хөтөлбөрийн Ховд аймгийн Засаг даргын ивээл дор зохион байгуулагдсан "Багачуудын хөгжилтэй гүйлт"<br>- УИХ-ын гишүүн Ж.Баясгалангийн аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй хийсэн уулзалт зэрэг 2 арга хэмжээг дохионы хэлний орчуулгатайгаар хүргэсэн. "Бэрх биш зэлтэй" аяны хүрээнд ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулах "Асуудал-Хөгжил" контентын уралдаан, аймгийн Нийгмийн даатгалын газраас "Duudlaga.mn" мэдээллийг дохионы хэлний орчуулгатай хүргэж, 1 удаагийн хандалтын тоо 4-5 мянга, давхардсан тоогоор 20 гаруй мянган хүн үзсэн байна. "Шидэт гар" дохионы хэлний анхан шатны сургалтыг 2 үе шаттай зохион байгуулж, 28 байгууллага, аж ахуйн нэгжийн 40 ажилтныг хамруулж, гэрчилгээ олговсон. Сургалтын үр дүнд 28 байгууллага, аж ахуйн нэгжээр хэл яриа, сонсголын бэрхшээлтэй иргэн үйлчилгээ авахад хүндрэл чирэгдэл учрахгүй, мэдээллийн хүртээмж, үйлчилгээний чанар сайжирлаа. | | 100 | Хэрэгжсэн |
| 55 | 3.3.3.10. | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөл, олон талт Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, шаардлагатай зардлыг шийдвэрлэх, салбар, байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | - | Төлөвлөгөөний хэрэгжилт 90.2 хувийн биелэлттэй байна. | 98.0 сая | ОНХС | Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 03 дугаар сарын 15-ны А/09 дугаар захирамжаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөлийг шинэчлэн байгуулж, зөвлөлийн бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон төрийн бус, хувийн нийт 24 байгууллагын төлөөллийг оруулан баталсан. Салбар зөвлөлийн хурлыг 2025 оны 01 дүгээр сарын 21-ны өдөр зохион байгуулж, 2024 оны үр дүн, 2025 оны төлөвлөгөөг хэлэлцэн баталсан. 2025 онд 7 зорилтын хүрээнд 41 арга хэмжээг нийт 146.1 сая төгрөгийн төсөв тусгасан бөгөөд төсвийн гүйцэтгэл 80 хувьтай байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 90.2 хувийн биелэлттэй байна. | | 90 | Хэрэгжсэн |
| 56 | 3.3.3.11. | Төрийн үйлчилгээний байгууллагын барилгын гадна байгууламжийн дотор талын хүртээмжийг сайжруулах; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Хүртээмжтэй болгосон байгууллагын тоо Үүнээс: эхний ээлжинд НДГ, ХХҮГ, ХГБХХГ, Нэг цэгийн үйлчилгээний төв | - | 3 | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Нийгмийн даатгалын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Нэг цэгийн үйлчилгээний төв, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв зэрэг 5 барилга байгууламж стандартад шаардлага хангасан. | 122.0 сая | ОНХС | Тайлант онд 53 байгууллагад барилга байгууламжийн хүртээмжийн үнэлгээ хийж, зөвлөмж өгч ажилласан байна. Үнэлгээнд хамрагдсан байгууллагуудын дундаж үнэлгээ-43.05%, хамгийн их нь-65.10%, хамгийн бага нь-17.9% байна.<br>Үнэлгээнд аймгийн ЗДТГ, Жаргалант сумын 7 сургууль, 15 цэцэрлэгийн барилга байгууламжид хүртээмжийн үнэлгээг хийж, дүнг холбогдох удирдлагуудад танилцуулж, 2 сургууль 7 цэцэрлэгийн орох хэсэг, ариун цэврийн өрөөнүүдийг хүртээмжтэй болгох зураг төслийг шинэчлэн боловсруулж, Монгол улсын стандартын шаардлагад нийцүүлэн 2026 онд засварлахаар төлөвлөсөн. Тэгш хамран сургах боловсролын хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор Ерөнхий боловсролын 25 сургууль, 33 цэцэрлэгт тус бүр 2 ширхэг тохируулагд ширээ сандлыг орон нутгийн төсвийн 122.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэж, сургалтын байгууллагуудад олголоо. Төрийн байгууллагуудын мэдээллийн хүртээмжийг сайжруулах зорилгоор зайнаас зөвлөн туслах төвийн үйлчилгээ /duudlaga.mn/-г Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв, Улсын бүртгэлийн хэлтэс, Нийгмийн даатгалын газар зэрэг байгууллагууд нэвтрүүлэн мэдээллийн хүртээмжийг сайжруулсан байна. | | 100 | Хэрэгжсэн |
| 57 | 3.3.3.12. | Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв байгуулах. | - | Хөгжлийн төвийн тоо | - | 1 | 2023 оны 09-р сард ХХБХТөв нь үйл ажиллагаагаа эхлүүлэн чиг үүргийнхээ хүрээнд тусламж үйлчилгээгээ үзүүлж байна. | - | - | Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр олон улсын жишигт нийцсэн, барилгын норм норматив стандарт шаардлагыг бүрэн хангасан төв 2023 оны 9 дүгээр сард ашиглалтад орж хөгжлийн бэрхшээлтэй иргэн төрийн үйлчилгээг нэг дороос авах нөхцөл бүрдэж хөгжлийн онцлог ялгаатай иргэдийн амьдралын чанарыг сайжруулахад томоохон ахиц дэвшил гарч байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвөөр 2025 оны жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор 8837 иргэн үйлчлүүлсэн байна. | | 100 | Хэрэгжсэн |
| | | | | | | | **НИЙТ** | | | | | **87.1** | |
| | | | | | | | | | | **3.3.4. Жендерийн эрх тэгш байдлыг хангах талаар:** | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 58 | 3.3.4.1. | Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд иргэдэд гэр бүлийн боловсрол олгох, жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрыг түшиглэн зохион байгуулна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | 1.Сургалт, мэдээллийн тоо<br>2.Сурталчилгаа, нөлөөллийн ажлын тоо | - | 5-аас доошгүй удаа зохион байгуулсан байна. | Жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр 12 төрлийн нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулсан. | | | Ховд аймгийн хэмжээнд "Харилцан хүндэтгэе" аяныг Хандлагаа өөрчилье, Хамтдаа үлгэрлэе уриан дор 2025 оны 03 дугар сарын 06 -наас 4 дүгээр сарын 06-ний өдрүүдэд Ховд аймгийн Засаг даргын тамгын газар, Засаг даргын эрхлэх хүрээний 25 агентлаг, Ховд аймгийн хөдөөгийн 16 сум, Аймгийн Жендэрийн салбар хороо, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүд, МУИС-ийн Баруун бүсийн сургууль, Хөгжил Политехник коллеж, Ховд аймагт үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагууд, Ховд аймгийн эмэгтэйчүүдийн холбоо, Зэвсэгт хүчний 123-р анги, Худалдаа үйлчилгээний төвүүд, Хүний эрхийн үндэсний комиссын Ховд аймаг дахь ахлах шинжээч М.Өнөрмаа, Ховд аймгийн Хүүхдийн элч, "Жаргалант хатан заяа" ТББ-ын тэргүүн М.Оюунсүрэн нартай хамтран тус аяныг зохион байгуулж нийт 10,000 орчим хүүхэд, 2000 гаруй насанд хүрэгчид хамрагдаж 12 төрлийн нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж ажиллалаа. | | 100 | Хэрэгжсэн |
| **НИЙТ** | | | | | | | | | | | | **100** | |
| **3.3.5. Ахмад настны талаар:** | | | | | | | | | | | | | |
| 59 | 3.3.5.1. | Ахмад настны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд олон нийтэд нөлөөллийн ажил зохион байгуулах; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажил 2 | - | Иргэдийн ахмад настны тухай хуулийн мэдлэг, мэдээлэл сайжирсан байна. | Нийгмийн халамжийн тухай хууль, ахмад настны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн талаар мэдээлэл, сургалтыг 29 удаа зохион байгуулсан. | - | - | 2025 онд нийт 29 удаагийн сургалт мэдээлэл өгч ажилласан. Аймгийн ахмадын хороо, сумдын ахмадын хорооны дарга нар болон Жаргалант сумын ахмадын хорооны тэргүүлэгч 50 ахмад, ХХҮГ-ын дэргэдэх ахмадын Цагаан уул амралтанд амарсан 17 сумдын 457 ахмад настан, Ховд аймгийн Жаргалант сумын хэмжээнд зохион байгуулагдсан Олон улсын ахмадын өдрийг тохиолдуулан Ахмадын баяр арга хэмжээнд 12 багийн нийт 600 гаруй ахмад настанд "Ахмад настны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, нийгмийн халамжийн тухай хуулийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл хийж сургалтыг зохион байгуулсан. Нийт давхардсан тоогоор 2000 гаруй ахмадуудад Нийгмийн халамжийн тухай хууль, Ахмад настны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн талаарх мэдээлэл, сургалтыг зохион байгуулан ажилласан. Ахмадуудад шинэ гарсан хууль тогтоомжийг цаг алдалгүй хүргэж, тэдний хууль эрхзүйн мэдлэгийг дээшлүүлэн, нийгмийн оролцоог идэвхижүүлэн, мэдлэг мэдээллээр хангасан зэрэг бодитой үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулсан. Ийм төрлийн сургалт арга хэмжээг тогтмол зохион байгуулж, ахмад настнуудын сайн сайхан амьдралд бодит хувь нэмэр оруулах шаардлагатай. | | 100 | Хэрэгжсэн |
| 60 | 3.3.5.2. | Ахмадын сан байгуулан ажиллуулах, тэтгэвэрт бэлтгэх төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд ААНБ-тай хамтран ажиллах, хяналт тавих; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | 1.Ахмадын сан байгуулсан байгууллагын тоо,<br>2.Тэтгэвэрт бэлтгэх төлөвлөгөө хэрэгжүүлсэн байгууллагын тоо | Ахмадын сан байгуулсан ААНБ-ын тоо, тэтгэвэр бэлтгэх төлөвлөгөөг хэрэгжүүлсэн ААНБ-ын тоо | ААНБ-ын 50-аас дээш хувь ахмадын сан байгуулсан байна. | Ахмадын сантай болсон 126 , тэтгэвэрт бэлтгэх төлөвлөгөөтэй 14 байгууллага байна. | - | - | Аймгийн Засаг даргын 2025 оны 1/642 тоот албан бичгээр төрийн байгууллагууд болон аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагуудад Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг хэрэгжүүлэн ажиллах тухай албан даалгаварыг гарган хүргүүлсэн. Албан даалгаврын хүрээнд Ховд аймагт үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага аж ахуйн нэгж 83 байгууллагын судалгаа ирсэн бөгөөд тэтгэвэрт бэлтгэх төлөвлөгөөг 14 байгуулага хэрэгжүүлэн ажиллаж байна. Тэтгэвэрт бэлтгэх төлөвлөгөөний хүрээнд бизнес санаа хөгжүүлэх, төсөл төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, бизнес эрхлэх ур чадварын сургалтыг 28 ахмад настанд Эм эс девелопмент консалтинг ХХК гүйцэтгэсэн байна. | | 100 | Хэрэгжсэн |
| 61 | 3.3.5.3. | Ахмад настны хөгжил, оролцоог дэмжих талаар авах арга хэмжээний болон Ахмадын ордон, өргөө байгуулах, тэдний үйл ажиллагаанд зарцуулах төсвийн саналыг боловсруулж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх, Ахмадын өргөөг ахмад настан бүрт нээлттэй байх талаар анхаарч ажиллах; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | 1.Баталсан төсвийн хэмжээ /сая.төг/<br>2.Үйлчилгээнд хамрагдсан ахмад настны тоо | Нийт ахмадын 60% | 20 -оос доошгүй хувьд хүрсэн байна. Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, үйлчилгээнд хамрагдсан ахмад настны тоо нэмэгдсэн байна. | Хөдөөгийн 5 суманд ахмадын өргөө, ордон байгуулахаар төлөвлөсөн ба тайлант онд Орон нутгийн төсвийн 130.0 сая төгрөгийн санхүүжилтээр Мөст сумын ахмадын өргөөг барьж, улсын комисс хүлээж авсан. | 259.2 сая | ОНТ | Ахмадын ордоны барилгад урсгал засвар хийхээр 50.0 сая төгрөг орон нутгийн төсөвт тусгасан боловч төсөв санхүүгийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалан тодотголоор хасагдсан. Ахмадын холбоо ахмадуудын дунд нийгэм соёл, спортын олон талт үйлчилгээнд давхардсан тоогоор 8000 гаруй ахмад настанд хамрагдаж 129.2 сая төгрөг зарцуулсан. | | 100 | Хэрэгжсэн |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 62 | 3.3.5.4. | Ахмадын идэвхтэй насжилтыг дэмжих төвийг байгуулж, ахмад настны эрэлт, хэрэгцээнд нийцсэн хөгжлийн болон нийгмийн үйлчилгээ үзүүлж, идэвхтэй насжилтыг дэмжих; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Үйлчилгээнд хамрагдсан тоо | - | Ахмадыг үйлчилгээнд бүрэн хамруулсан байна. | Хөгжлийн болон нийгмийн үйлчилгээнд 3154 гаруй ахмад, идэвхитэй насжилтыг дэмжих үйлчилгээнд 270 ахмад настан хамрагдсан. | - | - | Ахмад настны хөнгөлөлт, тусламжийн үйлчилгээнд давхардсан тоогоор 3154 ахмад хамрагдаж 594.9 сая төгрөг, алдар цолтон ахмад настны хөнгөлөлт, тусламж үйлчилгээнд 65 ахмад настанд 20.3 сая төгрөг, насны хишиг олгох үйлчилгээнд 65-69 настай 2184, 70-79 настай 1857 , 80-89 настай 693, 90-ээс дээш настай 89 ахмад настанд нийт 4823 ахмадад 717,8 сая төгрөгийг зарцуулсан байна. Баруун бүсийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн сэргээх төвд нийт 19 асруулагч асруулж байгаагаас 8 ахмад настан төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байна | | 100 | Хэрэгжсэн |
| 63 | 3.3.5.5. | Ахмад настны бие бялдар, танин мэдэхүй, сэтгэлзүй, үйл ажиллагааны чадвар, нийгмийн тулгамдсан асуудлыг тодорхойлох цогц үнэлгээ хийх ажлыг орон нутгийн түвшинд зохион байгуулах; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Цогц үнэлгээнд хамрагдсан ахмад настны тоо | - | Ахмад настны бие бялдар, танин мэдэхүй, сэтгэлзүй, үйл ажиллагааны чадвар, нийгмийн тулгамдсан асуудлыг тодорхойлох цогц үнэлгээ хийгдсэн байна. | Ахмад настны цогц үйлчилгээнд 345 ахмад хамрагдсан. | 50.0 сая | - | Ахмад настны цогц тусламж үйлчилгээний хүрээнд ахмад настнуудын бие бялдар, танин мэдэхүй, сэтгэлзүйн үйл ажиллагааны чадвар, нийгмийн тулгамдсан асуудлыг тодорхойлох цогц үнэлгээ идэвхитэй насжилтыг дэмжих үйлчилгээнд 270 ахмад настан, гэрээр асрах үйлчилгээнд 75 ахмад настан нийт 345 ахмад настан цогц үйлчилгээнд хамрагдлаа. | | 100 | Хэрэгжсэн |
| 64 | 3.3.5.6. | Ахмад настанд цогц тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтныг мэргэшүүлэх, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийг байгуулан, үйл ажиллагааг тогтмолжуулж, хяналт тавих; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | 1.Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийг байгуулсан эсэх<br>2.Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийн тайлангийн тоо | - | Ахмад настанд үзүүлэх цогц тусламж, үйлчилгээ тогтмолжиж сайжирсан байна. | Аймгийн Засаг даргын А/520 дугаар захирамжаар орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийг 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулан төлөвлөгөөгөө батлан, холбогдох дээд шатны байгууллагад тайлант хүргүүлсэн. | - | - | Ахмад настанд цогц үнэлгээ хийх, тусламж үйлчилгээ үзүүлэх журмын хэрэгжилтийг хангах хүрээнд ахмад настны шинэ төрлийн үйлчилгээ буюу идэвхтэй насжилтыг дэмжих үйлчилгээ, өдрөөр асрах үйлчилгээ, гэрээр асрах үйлчилгээ гэсэн 3 багц үйлчилгээг төрийн бус байгууллагаар үзүүлэх бараа, ажил, үйлчилгээний нээлттэй тендерийг 2025 оны 04 дүгээр сарын 23-аас 05 дугаар сарын 14-ний өдөр хүртэл зарласан бөгөөд 2025 оны 8 сарын 1 өдөр тендер шалгаруулалтын журмын дагуу " Ачлалт нарен хайрхан" ХХК Ивээл эмнэлэг шалгаран идэвхитэй насжилтыг дэмжих үйлчилгээ, Гэрээр асрах үлчилгээг хэрэгжүүлэхээр шалгаран 2025 оны 06 дугаар сараас эхлэн үйл ажиллагаа эрхлэн явуулж байна. Идэвхитэй насжилтыг дэмжих үйлчилгээнд 270 гаруй ахмад настан хамрагдсан бөгөөд лавлагаа мэдээллийн үйлчилгээ, зөвөлгөө өгөх үйлчилгээ, хөнхлийн дэмжих үйлчилгээ, зөв хооллолт дасгал хөдөлгөөн, эрүүл мэндийг дэмжих үйлчилгээ, гэр бүлийн хүчирхийллээс хамгаалагдах үйлчилгээг хүргэн ажиллаж байна.Гэрээр асрах үйлчилгээнд байнгын асаргаа шаардлагатай 75 ахмад хамрагдсан бөгөөд гэрээр асрах үйлчилгээнд ахмрагдлаа.Эдгээр үйлчилгээний үр дүнд байнгын асаргаа шаардлагатай ахмад настнуудын амьдралын чанар дээшилж, бие даан амьдрах чадвар нь сайжирсан. Мөн тэдний сэтгэл санааны байдал тогтворжиж, нийгмийн идэвх оролцоо нэмэгдсэн байна. Аймгийн Засаг даргын А/520 дугаар захирамжаар орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийг 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулан төлөвлөгөөгөө батлан, сумдын Засаг дарга нар, эрүүл мэндийн салбарын байгууллагуудад | | 100 | Хэрэгжсэн |
| 65 | 3.3.5.7 | Ахмад настнаа хүндлэх, ёс заншил, уламжлалаа өвлүүлэх, мэдлэг, туршлагыг нь залуу үед хүргэх арга хэмжээг зохион байгуулах, ахмад настныг ажиллаж байсан байгууллага болон бүх шатны боловсролын байгууллагад сар бүр сургалт хийлгэх, ахлах ангийн сурагч, оюутнуудыг ахмад настанд технологийн, цахим орчин, цахим үйлчилгээний сургалт явуулах зэрэг сайн дурын ажилд татан оролцуулах, урамшуулах; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | 1.Бүх шатны боловсролын байгууллагад сургалт хийсэн ахмад настны тоо<br>2.Ажиллаж байсан байгууллагадаа сургалт хийсэн ахмад настны тоо | - | Ахмад настнаа хүндлэх, ёс заншил, уламжлалаа өвлүүлэх, мэдлэг, туршлагыг нь залуу үед хүргэх арга хэмжээг зохион байгуулсан байна. | Ахмад мэргэжилтний нийгмийн оролцоог нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэх, орлогоо нэмэгдүүлэх, эзэмшсэн мэдлэг, ажлын туршлагыг хойч, залуу үед өвлүүлэх, зөвлөх үйлчилгээнд 70 ахмад настан хамрагдаж 18 байгууллагад сургалт, зөвлөн, туслах үйлчилгээг зохион байгуулсан байна. | 299.0 | ХЭДС | Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 63 иргэнээс төсөл хүлээн авч ажлын байранд нөхцөл байдлын үнэлгээ хийж 52 иргэнд 299.0 сая төгрөгийг 24 сарын хугацаанд эргэн төлөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг олгосон. Ахмад мэргэжилтний нийгмийн оролцоог нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэх, орлогоо нэмэгдүүлэх, эзэмшсэн мэдлэг, ажлын туршлагыг хойч, залуу үед өвлүүлэх, зөвлөх үйлчилгээнд 70 ахмад настан хамрагдаж 75,6 сая төгрөгийг зарцуулсан байна. Ахмад настан ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд хамрагдасан ахмадууд 18 байгууллагад сургалт арга хэмжээ, зөвлөн, туслах үйлчилгээг зохион байгуулсан байна. | | 100 | Хэрэгжсэн |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 66 | 3.3.5.8 | Ганц бие орон гэргүй, эсхүл түр байрлуулах газарт байсан иргэн нас барсан, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн нас барсан бол оршуулах үйл ажиллагаа зохион байгуулах, санхүүжүүлэх журмыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан хэрэгжүүлэх; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | 1.Журам баталсан эсэх<br>2.Оршуулах үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ /сая төг/ | - | Журмыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулсан байна. Ганц бие орон гэргүй ахмад настанд үзүүлэх үйлчилгээ сайжирсан байна. | Оршуулах үйл ажиллагаанд зардал гараагүй болно. | - | - | Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2-т "нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн, иргэн нас барж, гэр бүл асран хамгаалагч, хамаатан садангийн хүн хүсэлт гаргасан тохиолдолд оршуулгын үйл ажиллагаа зохион байгуулах, оршуулгын үйл ажиллагаанд тэтгэмж олгоход холбогдсон харилцааг зохицуулах журмын төслийг нийгмийн халамжийн хэлтсийн мэргэжилтэн нар боловсруулан Аймгийн Иргэдийн төлөөлөгчдын хурлын ажлын албанд хүргүүлсэн бөгөөд журам батлагдаагүй байна. | | 100 | Хэрэгжсэн |
| 67 | 3.3.5.9. | Хөдөлмөрийн тухай хуулийн 145.4-т заасан "Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 50 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа 2 хувиас доошгүй орон тоонд Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хүнийг газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлтэй ажлын байрнаас бусад ажлын байранд ажиллуулна." гэсэн заалтын хэрэгжилтийг хангуулж ажиллах, хяналт тавих; | - | 50-иас дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагад хуулийн дагуу ажиллах ёстой ахмад настны тоо, үүнээс ажиллаж байгаа ахмад настны тоо | Суурь түвшний тоо | Хөдөлмөрийн тухай хуулийн 145.4 дэх хэсгийн хэрэгжилт хангагдаж ахмадуудын хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна. | Ахмадын хөдөлмөр эрхлэлтийн судалгаат зохион байгуулахаар ХХҮГ, НДХ хамтарсан ажлын хэсэг байгуулсан. | - | - | Ахмадын хөдөлмөр эрхлэлтийн судалгаат зохион байгуулахаар ХХҮГ, НДХ хамтарсан ажлын хэсэг байгуулан 170 гаруй байгууллагад албан тоот хүргүүлж нэгтгэл хийгдэж дуусаагүй байна. | | 50 | Хэрэгжээгүй |
| 68 | 3.3.5.10. | Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9.2 дахь заалтын хэрэгжилтийг хангах чиглэлээр орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллах. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | 1.Тухайн жилийн татвар ногдох орлогоос 1 хүртэлх хувийг нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан байгууллагын тоо | - | Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9.2 дахь заалтын хэрэгжилт хангагдсан байна. | Татвар ногдох орлогоос 1 хүртэлх хувийг нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан байгууллага байхгүй. | - | - | Ттатвар ногдох орлогоос 1 хүртэлх хувийг нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан байгууллага байхгүй. | | 100 | Хэрэгжсэн |
| НИЙТ | | | | | | | | | | | | 95 | |
| ДУНДАЖ ХУВЬ | | | | | | | | | | | | 85.4 | |

ХЯНАСАН:
ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ М.БАЯРТ

НЭГТГЭСЭН:
НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН Б.ДАВААЖАРГАЛ